

1 Удиртгал

Энэ дүрэм нь хэрэглэгчийн эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор мал, амьтны эрүүл мэнд, хүрээлэн буй орчны холбогдох асуудлыг харгалзан үзэж хүнсний сүлжээг бүхэлд нь хамарсан хүнсний зориулалтын мал, амьтны тэжээлийн аюулгүй байдлын тогтолцоог бий болгоход оршино. Энэ дүрэм Хүнсний хууль, эрх зүйн хороо (ХХЭЗХ)¹-оос тогтоосон хүнсний эрүүл ахуйн зарчмын нэмэлт бөгөөд мал, амьтны тэжээх онцлог талыг харгалзсан болно.

¹ Зөвлөмж болгож буй олон улсын дадлын дүрэм – Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (CAC/RCP 1-1969).

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код

Мал, амьтны тэжээл, тэжээллэгийн зохистой дадлын дүрэм	MNS CAC RCP 54:202.
Code of practice on good animal feeding	CAC/RCP 54-2004-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 202. оны ... дүгээр сарын ...-ний өдрийн ... дүгээр тушаалаар батлав.

Энэ стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

2 Зорилго, хамрах хүрээ

2. Энэ дүрмийн зорилго нь хот айл, фермийн түвшинд мал, амьтан тэжээх зохистой дадлыг дагаж мөрдөх, түүнчлэн хүнсний зориулалтын мал, амьтны тэжээл, тэжээлийн орц худалдан авах, харьцах, хадгалах, боловсруулах, түгээх явцад үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ыг дагаж мөрдөх замаар хүний хэрэгцээнд зориулсан хүнсний аюулгүй байдлыг хангахад туслах явдал юм.

3. Үйлдвэрийн аргаар эсхүл хот айл, фермийн нөхцөлд үйлдвэрлэснээс үл хамааран мал, амьтны тэжээл, тэжээлийн орцод зориулсан аливаа материалыг үйлдвэрлэх, хэрэглэхэд энэ дадлын дүрмийг хэрэглэнэ. Энэ дүрэмд бэлчээрийн болон хагас байран маллагаатай мал амьтныг тэжээх, тэжээлийн ургамал тариалах, усны аж ахуйд холбогдох асуудал мөн хамаарна.

4. Хүнсний аюулгүй байдалд холбогдох мал, амьтны эрүүл мэндийн асуудлаас бусад мал, амьтны тавлаг байдлын асуудал энэ дүрэмд хамаарахгүй. Тэжээл, тэжээлийн орцод агуулагдах орчны бохирдуулагч бодисын түвшин мал, амьтны гаралтай хүнс хэрэглэсний улмаас хэрэглэгчийн эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй тохиолдолд анхаарч үзнэ.

5. Тэжээлийн аюулгүй байдлын тогтолцоогоор хэрэглэгчийн эрүүл мэндээс гадна мал, амьтны эрүүл мэнд, хүрээлэн буй орчны асуудлыг цогцоор нь авч үзэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч энэ дадлын дүрэмд Хүнсний хууль, эрх зүйн хорооны хэрэглэгчийн эрхийг хамгаалах бүрэн эрхийн хүрээнд зөвхөн хүнсний аюулгүй байдлыг онцлон анхааран авч үзнэ. Гэвч энэ дадлын дүрэм дэх зөвлөмж болон арга дадлыг малын тэжээллэгт холбогдох мал, амьтны эрүүл мэнд, хүрээлэн буй орчны ерөнхий асуудалд харшлахгүй байхаар оруулсан болно.

3 Нэр томъёо, тодорхойлолт

6. Энэ дүрмийн хүрээнд дараах тодорхойлолтыг хэрэглэнэ:

ТЭЖЭЭЛ

хүнсний зориулалтын мал, амьтанд шууд өгч тэжээх зориулалттай боловсруулсан, хагас боловсруулсан эсхүл түүхий эд, материал (дан эсхүл олон найрлагатай).

ТЭЖЭЭЛИЙН ОРЦ

тэжээллэг чанартай эсэхээс үл хамааран мал, амьтны тэжээлд ордог бүрэлдэхүүн хэсэг, аливаа нэгдэл, холимгийг бүрдүүлэгч бөгөөд үүнд тэжээлийн хольц мөн

орно. Орц нь газрын болон усны ургамал, амьтны гаралтай, эсхүл бусад органик, органик бус бодис байна.

тэжээлийн хольц²

тэжээл эсхүл мал, амьтны бүтээгдэхүүний шинж чанарт нөлөөлдөг, ихэвчлэн дангаар нь тэжээл болгон хэрэглэдэггүй, тэжээллэг чанартай эсэхээс үл хамааран зориудаар нэмсэн аливаа орц

хэрэгцээгүй бодис

тэжээл болон тэжээлийн орцын дотор болон гадаргууд оршиж, хүнсний аюулгүй байдалд нөлөөлж мал, амьтны эрүүл мэндийн асуудал үүсгэх зэргээр хэрэглэгчийн эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй бохирдуулагч болон бусад бодис

эмжүүлсэн тэжээл

ХХЭЗХ-ны “Процедурын гарын авлага”-д тодорхойлсон мал эмнэлгийн эм агуулж байгаа аливаа тэжээл

4 Ерөнхий зарчим, шаардлага

7. Тэжээл, тэжээлийн орцыг үйлдвэрлэх, харьцах, хадгалах, тээвэрлэх явцад хортон шавжаар, хими, физик, микробиологийн бохирдуулагчаар, эсхүл бусад хэрэгцээгүй бодисоор бохирдохоос хамгаалахын тулд тэдгээрийн тогтвортой байдлыг алдагдуулахгүй нөхцөлд авч, хадгална. Тэжээл нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн чанарын стандартыг хангасан байна. Хүнсэнд тохиолдож болзошгүй аюулыг хянахын тулд зохих тохиолдолд хөдөө аж ахуйн зохистой дадал, үйлдвэрлэлийн зохистой дадал, шаардлагатай нөхцөлд Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт (АДШЭЦХ)-ын зарчим³ зэргийг дагаж мөрдөнө. Хүрээлэн буй орчноос үүсэж болзошгүй бохирдлын боломжит эх үүсвэрийг харгалзаж үзнэ.

8. Учирч болзошгүй аюул, түүний хэрэглэгчийн эрүүл мэндэд учруулах эрсдэлийн түвшинг тогтоох зорилгоор тэжээл, тэжээлийн орц үйлдвэрлэгч, хүнсэнд хэрэглэх мал, амьтан маллагч, мал, амьтны энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч талууд хамтран ажиллана. Ийм хамтын ажиллагаа нь эрсдэлийн менежментийн зохих хувилбарыг хэрэгжүүлэх, аюулгүй байдлаар тэжээл үйлдвэрлэх, хэрэглэх дадлыг боловсруулах, сахин мөрдөх боломжийг бүрдүүлнэ.

4.1 Тэжээлийн орц

9. Тэжээлийн орцыг аюулгүй эх үүсвэрээс авах бөгөөд хэрэв орцыг хүнсний аюулгүй байдлын үүднээс урьд өмнө нь үнэлгээ хийгдээгүй арга, технологиор гаргаж авсан бол “Кодекс алиментариусийн хүрээнд хэрэглэх эрсдэлийн дүн шинжилгээний ажлын зарчим”⁴-д нийцсэн эрсдэлийн дүн шинжилгээнд хамруулна. Ялангуяа тэжээлийн хольц үйлдвэрлэгч бүтээгдэхүүнийхээ зөв, аюулгүй хэрэглээний талаар тодорхой мэдээлэл хэрэглэгчдэд өгнө. Тэжээлийн орцын хяналт-шинжилгээнд эрсдэлд суурилсан аргазүйг ашиглан тэжээлийн орцыг хянан шалгах, түүнд хэрэгцээгүй бодис байгаа эсэхийг тодорхойлох үүднээс сорьц түүвэрлэж, шинжилгээ хийх ажлыг оруулна. Тэжээлийн орцод агуулагдах

² Бичил биетэн, энзим, хүчиллэг тохицуулагч, бичил махбод, аминдэм болон бусад бүтээгдэхүүнийг тэдгээрийн хэрэглэх зориулалт, олгох аргаас хамааран энэ тодорхойлолтод оруулна.

³ “Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт” гэдгийг зөвлөмж болгож буй олон улсын дадлын дүрэм болох “Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим” (CAC/RCP 1-1969)-ын хавсралтад тодорхойлсноор ойлгоно.

⁴ Хүнсний хууль, эрх зүйн хорооны “Процедурын гарын авлага”.

хэрэглэгчийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй эмгэг төрүүлэгч, мөөгөнцрийн хор, пестицид, хэрэгцээгүй бодисын хэмжээ зөвшөөрөгдөх түвшинд буюу хууль тогтоомжоор тогтоосон стандарт түвшинд байна.

4.2 Шошгололт

10. Шошго нь тэжээл, тэжээлийн орцыг хэрэглэгч хэрхэн харьцаж, хадгалах, хэрэглэх талаар тодорхой, дэлгэрэнгүй мэдээлэл агуулна. Шошго нь хууль тогтоомжийн аливаа шаардлагад нийцсэн байх ба тэжээлийг хэрэглэх зааврыг тодорхой оруулсан байна. Шошго эсхүл дагалдах бичиг баримт нь зохих тохиолдолд дараах агуулгатай байна:

- a. тэжээлийг хэрэглэх мал, амьтны төрөл, зүйл,
- b. тэжээлийг хэрэглэх зориулалт,
- c. тэжээлийн орцын жагсаалт, тэжээлийн хольцын лавлах мэдээлэл, орцын эзлэх хувийг буурах дарааллаар мэдээлэх,
- d. үйлдвэрлэгч эсхүл бүртгүүлэгчийн холбоо барих мэдээлэл,
- e. байгаа бол бүртгэлийн дугаар,
- f. хэрэглэх заалт, сэрэмжлүүлэг,
- g. цувралын дугаар,
- h. үйлдвэрлэсэн огноо,
- i. хэрэглэх хугацаа эсхүл хүчинтэй хугацаа.

11. Энэ дэд хэсгийн заалт нь орчин үеийн биотехнологийн аргаар гарган авсан тэжээл, тэжээлийн орцын шошгод хамаарахгүй⁵.

4.3 Тэжээл, тэжээлийн орцыг мөшгөн тогтоох, ул мөрийг мөрдөн тогтоолт, бүртгэл хөтлөлт

12. Хэрэглэгчийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа нь мэдэгдсэн эсхүл үзүүлэх боломжтой гэж таамагласан бүтээгдэхүүнийг зах зээлээс нэн даруй, үр дүнтэй эргүүлэн татан авах, буцаан авахын тулд зохих бүртгэл хөтөлж тэжээл, тэжээлийн орц, түүний дотор тэжээлийн хольцыг мөшгөн тогтоох/ул мөрийг мөрдөн тогтоох боломжийг бүрдүүлнэ. Тэжээл, тэжээлийн хольцын үйлдвэрлэл, борлуулалт, хэрэглээний талаар бүртгэлийг тогтмол хөтөлж, ашиглахад бэлэн байлгах бөгөөд ингэснээр хэрэв хэрэглэгчийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа нь мэдэгдсэн эсхүл үзүүлж болзошгүй гэж таамагласан тохиолдолд тэжээл, тэжээлийн хольцыг шууд өмнөх эх үүсвэр хүртэл эргэж мөшгөх болон тэдгээрийн дараагийн хүлээн авагч хүртэл хөөж мөшгөх боломжтой болно⁶.

4.3.1 Ноцтой нөхцөл байдалд хэрэглэх тусгай болзол

13. Хэрэв тэжээл, тэжээлийн орц энэ дүрмээр тогтоосон тэжээлийн аюулгүй

⁵ Хүнсний шошгололтын Кодексийн хорооноос авч хэлэлцэж байгаа хүнсний шошгоны талаарх шинэчлэлийн хүрээнд орчин үеийн биотехнологийн аргаар гарган авсан мал, амьтны тэжээл, тэжээлийн орцыг хэрхэн яаж шошголохыг шийдвэрлэхээр хүлээгдэж байна.

⁶ Мөшгөн тогтоох/бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох нарийвчилсан арга хэмжээг боловсруулах нь зүйтэй: "Хүнсний хяналт шалгалт ба гэрчилгээжүүлэлтийн системийн арга хэрэгсэл болгон мөшгөн тогтоох/бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох зарчим" (CAC-GL 60-2006).

байдлын шаардлагыг хангахгүй бол үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн эрх бүхий байгууллагад богино хугацаанд мэдэгдэнэ. Мэдээлэл нь аль болох дэлгэрэнгүй байх бөгөөд наад зах нь тухайн асуудлын шинж чанар, тэжээл, тэжээлийн орцын тодорхойлолт, тэдгээрийг хэрэглэх зориулалтын мал, амьтны төрөл, зүйл, тухайн цувралын ялган таних дугаар, үйлдвэрлэгчийн нэр, гарал үүсэл зэргийг агуулсан байна. Ийм тэжээл, тэжээлийн орц нь хэрэглэгчийн эрүүл мэндэд аливаа аюул учруулахаас сэргийлэхийн тулд эрх бүхий байгууллага болон үйл ажиллагаа эрхлэгч нэн даруй үр дүнтэй арга хэмжээ авна.

14. Хэрэглэгчийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй тодорхой тэжээл, тэжээлийн орцыг өөр улсад худалдаалах нь тодорхой болсон нөхцөлд экспортлогч улсын эрх бүхий байгууллага холбогдох импортлогч улсын эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Мэдэгдэл нь аль болох дэлгэрэнгүй байх бөгөөд өмнөх хэсэгт заасан мэдээллийг агуулсан байна.

4.4 Хяналт шалгалт ба хяналтын журам

15. Тэжээл, тэжээлийн орц үйлдвэрлэгч болон салбарын бусад холбогдох тал эдгээр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэхэд тавигдах стандарт шаардлагыг ханган ажиллахын тулд өөрийн дотоод журам, хяналтыг хэрэгжүүлнэ. Түүнчлэн хүний хэрэгцээнд зориулагдсан мал, амьтны гаралтай хүнс нь аюулгүй бөгөөд тохиромжтой байх нөхцөлийг хангаж тэжээл, тэжээлийн орцыг үйлдвэрлэсэн, түгээсэн, хэрэглэсэн болохыг шалгахын тулд эрсдэлд суурилсан албан ёсны зохицуулалтын хөтөлбөрийг бий болгох шаардлагатай. Хүнсээр дамждаг аюулаас⁷ хэрэглэгчийг хамгаалахын тулд тэжээл, тэжээлийн орц нь шаардлага хангаж байгааг магадлан шалгахад ашиглах хяналт шалгалт хийх болон хяналтын арга хэмжээ авах журамтай байна. Хяналт шалгалтын ажлыг тухайн нөхцөл байдалд тохирсон эрсдэлийн бодит үнэлгээнд тулгуурлан төлөвлөж, хэрэгжүүлнэ⁸. Эрсдэлийн үнэлгээ хийхэд ашиглаж буй аргазүй нь олон улсад хүлээн зөвшөөрсөн арга барилд нийцсэн байна. Эрсдэлийн үнэлгээ нь орчин үеийн шинжлэх ухааны нотолгоонд суурилна.

16. Салбарын эсхүл албан ёсны хяналтын байгууллагаас хийх хяналт-шинжилгээнд тэжээл, тэжээлийн орцод хяналт шалгалт хийх, тэдгээрт агуулагдах хэрэгцээгүй бодисын үл зөвшөөрөгдөх түвшинг илрүүлэх зорилгоор сорьц түүвэрлэж, шинжилгээ хийх ажлыг оруулна.

4.5 Мал, амьтны тэжээлтэй холбоотой эрүүл мэндэд учрах аюул

17. Аливаа тэжээл, тэжээлийн орц нь аюулгүй байдлын ерөнхий стандартыг хангасан байна. Тэжээл, тэжээлийн орцод агуулагдах хэрэгцээгүй бодисын түвшинг аль болох хамгийн бага түвшинд байлгах зайлшгүй шаардлагатай бөгөөд ингэснээр хүний хэрэглээнд зориулагдсан хүнсэнд агуулагдах хэрэгцээгүй бодис үл зөвшөөрөгдөх түвшнээс байнга доогуур байна. Мал, амьтны тэжээлд зориулан ХХЭЗХ-оос тогтоосон “Үлдцийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” болон “Гадны биетийн үлдцийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”-г дагаж мөрдөнө. ХХЭЗХ зэргээс хүнсэнд зориулан тогтоосон “Үлдцийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” нь тэжээлийн аюулгүй байдлын ерөнхий стандартыг тодорхойлоход тустай.

4.5.1 Эмжүүлсэн тэжээлд ашиглах тэжээлийн хольц, мал эмнэлгийн эм

18. Эмжүүлсэн тэжээлд ашиглах тэжээлийн хольц болон мал эмнэлгийн эмийн

⁷ “Хүнсний импорт, экспортын хяналт шалгалт ба гэрчилгээжүүлэлтийн зарчим” (CAC/GL 20-1995).

⁸ “Хүнсний импорт, экспортын хяналт шалгалт ба гэрчилгээжүүлэлтийн системийг төлөвлөх, ажиллуулах, үнэлэх, магадлан итгэмжлэх удирдамж” (CAC/GL 26-1997).

аюулгүй чанарыг үнэлэх ба тэдгээрийг эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн хэрэглэх нөхцөлийг баримтлан хэрэглэнэ.

19. Эмжүүлсэн тэжээлд ашиглах мал эмнэлгийн эм нь “Мал эмнэлгийн эмийн хэрэглээг хянахад зориулсан ХХЭЗХ-оос зөвлөсөн олон улсын дадлын дүрэм⁹”-ийн шаардлагыг хангасан байна.

20. Буруу хэрэглээнээс сэргийлэхийн тулд тэжээлийн хольц болон эмжүүлсэн тэжээлд хэрэглэж байгаа мал эмнэлгийн эмийн хооронд нарийн зааг тогтоож өгнө.

21. Тэжээлийн хольцыг хүлээн авах, харьцах, хадгалахдаа түүний бүрэн бүтэн байдлыг хадгалж, буруугаар хэрэглэхгүй байх бөгөөд аюул учруулж болзошгүй бохирдлыг хамгийн бага түвшинд байлгана. Тэжээлийн хольц агуулсан тэжээлийг хэрэглэхдээ түүний тодорхой заасан зааврыг ягштал дагаж мөрдөнө.

22. Нийтийн эрүүл мэндийн аюулгүй байдлын нөлөөллийн үнэлгээ хийгдээгүй тохиолдолд антибиотикийг өсөлт идэвхжүүлэх зорилгоор тэжээлд хэрэглэж болохгүй¹⁰.

4.5.2 Тэжээл, тэжээлийн орц

23. Тэжээл, тэжээлийн орцыг зөвхөн аюулгүй бөгөөд тохиромжтой байдлаар үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлж, хадгалж, хэрэглэх бөгөөд зориулалтаар нь хэрэглэхэд хэрэглэгчийн эрүүл мэндэд үл зөвшөөрөгдөх эрсдэл ямар нэг байдлаар учруулахгүй байна. Ялангуяа, хэрэгцээгүй бодисоор үл зөвшөөрөгдөх түвшинд бохирдсон тэжээл, тэжээлийн орцыг мал, амьтны тэжээлд тохирохгүй гэж тодорхой ялган тогтоож, зах зээлд нийлүүлэх, хэрэглэхийг хориглоно.

24. Тэжээл, тэжээлийн орцыг хэрэглэгчийг төөрөгдүүлэх байдлаар сурталчилж, зах зээлд нийлүүлж болохгүй.

4.5.3 Хэрэгцээгүй бодис

25. Тэжээл, тэжээлийн орц дахь үйлдвэрлэлийн болон хүрээлэн буй орчны бохирдуулагч, пестицид, радио идэвхт бодис, удаан хадгалагдах органик бохирдуулагч, эмгэг төрүүлэгч бодис, хор (хөгц, мөөгөнцрийн хор гэх мэт) зэрэг хэрэгцээгүй бодисыг ялган тогтоож, хяналт тавьж, хамгийн бага түвшинд байлгана. Үхрийн тархи сархиатах өвчин үүсгэгч бодис¹¹ (ҮТСӨ)-ын эх үүсвэр байж болзошгүй амьтны гаралтай бүтээгдэхүүнийг хивэгч малд шууд өгч тэжээж, эсхүл хивэгч малд зориулсан тэжээл үйлдвэрлэхэд ашиглаж болохгүй. Хэрэгцээгүй бодисын үл зөвшөөрөгдөх түвшинг бууруулахад чиглэсэн хяналтын арга хэмжээг хүнсний аюулгүй байдалд хэр зэрэг нөлөөлж байгаагаар нь үнэлнэ.

26. Хэрэгцээгүй бодис тус бүрийн хэрэглэгчийн эрүүл мэндэд учруулах эрсдэлийг үнэлэх бөгөөд энэ үнэлгээний дүнд үндэслэн тэдгээрийн тэжээл, тэжээлийн орцод байх зөвшөөрөгдөх дээд түвшинг тогтоох эсхүл мал, амьтны тэжээлд тодорхой материалыг ашиглахыг хориглож болно.

⁹ SAC/RCP 38-1993.

¹⁰ ДЭМБ-ын Хүнсний зориулалттай мал, амьтанд бичил биетний тэсвэржилт (ББТ)-ийг хязгаарлах зарчим, 2000 оны 6-р сар, Женев хот.

¹¹ ДЭМБ/ХХАБ/ДМАЭМБ-ын хамтарсан ҮТС өвчний талаарх техникийн зөвөлгөөн: нийтийн эрүүл мэнд, мал, амьтны эрүүл мэнд болон худалдаа, ДМАЭМБ-ын Төв байр, Парис хот, 2001 оны 6-р сарын 11-14

5 Тэжээл, тэжээлийн орцын үйлдвэрлэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт

27. Аюулгүй, тохиромжтой тэжээл, тэжээлийн орц үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, түгээх нь хүнсний сүлжээнд оролцогч бүрийн, түүний дотор малчин, фермер, тэжээлийн орц үйлдвэрлэгч, холимог тэжээл үйлдвэрлэгч, тээвэрлэгч зэргийн хариуцлага юм. Хүнсний сүлжээнд оролцогч бүр өөрийн шууд хяналтанд байгаа бүх үйл ажиллагааг, ялангуяа хууль тогтоомжоор тогтоосон холбогдох аливаа шаардлагыг биелүүлэх ажлыг хариуцан ажиллана.

28. Тэжээл үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, түгээхэд тэжээл, тэжээлийн орцын аюулгүй байдалд нөлөөлж, улмаар хэрэглэгчийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхэд хүргэж болзошгүй үйл ажиллагаанд үл нийцэх ажлын байр, байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглаж болохгүй. Усны аж ахуй нь онцлог шинж чанартай тул эдгээр ерөнхий зарчмыг хэрэглэхдээ усны аж ахуй болон хуурай газар түшсэн үйлдвэрлэлийн хоорондын ялгааг харгалзаж үзнэ.

29. Үйл ажиллагаа эрхлэгч зохих тохиолдолд хүнсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй аюулыг хянахын тулд үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ыг, боломжтой бол АДШЭЦХ-ын зарчмыг мөрдөнө. Үүний зорилго нь бүх аюулыг бүрэн арилгах боломжгүйг хүлээн зөвшөөрч аль болох тохирох аргаар тэжээлийн аюулгүй байдлыг хангах, ялангуяа мал, амьтны тэжээл болон мал, амьтны гаралтай хүнс бохирдохоос хамгаалахад оршино.

30. Үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP), боломжтой бол АДШЭЦХ-д суурилсан арга барилыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь ялангуяа дараах чиглэлийн асуудлыг шийдвэрлэнэ:

5.1 Барилга байгууламж

31. Тэжээл, тэжээлийн орц боловсруулахад ашиглах барилга, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар, техникийн үйлчилгээ хийх, цэвэрлэхэд хялбар, тэжээлийн бохирдлыг аль болох бага байлгах аргаар угсарч, барьсан байна. Үйлдвэрийн байрны доторх үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тэжээлийн бохирдол аль болох бага байхаар төлөвлөсөн байна.

32. Тэжээл үйлдвэрлэхэд ашиглах ус эрүүл ахуйн шаардлага хангасан байх бөгөөд усны чанар нь мал, амьтанд тохирсон байна. Ус хадгалах, дамжуулахад ашиглах усны нөөцлүүр, хоолой, бусад тоног төхөөрөмж нь аюултай түвшний бохирдол үүсгэдэггүй, зохих материалаар хийгдсэн байна.

33. Бохир ус, хаягдал болон борооны усыг тоног төхөөрөмж, тэжээл, тэжээлийн орцыг бохирдуулахгүй байх аргаар зайлуулна.

5.2 Хүлээн авах, хадгалах, тээвэрлэх

34. Химийн бордоо, пестицид болон тэжээл, тэжээлийн орцод хэрэглэх зориулалтгүй бусад материалыг үйлдвэрлэлд болзошгүй алдаа гаргах, тэжээл, тэжээлийн орцыг бохирдуулахаас хамгаалан тэжээл, тэжээлийн орцоос тусад нь хадгална.

35. Боловсруулсан тэжээл, тэжээлийн орцыг боловсруулаагүй тэжээл, тэжээлийн орцоос тусад нь хадгалж, зохих савлагааны материалыг ашиглана. Тэжээл, тэжээлийн орцыг хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй түвшинд

хүртэл бохирдуулахаас сэргийлж аливаа хөндлөнгийн бохирдолыг дээд зэргээр бууруулсан байдлаар хүлээн авч, хадгалж, тээвэрлэнэ.

36. Тэжээл, тэжээлийн орцод хэрэгцээгүй бодис байгаа эсэхэд хяналтшинжилгээ хийж, хянана.

37. Тэжээл, тэжээлийн орцыг аль болох богино хугацаанд түгээж, хэрэглэнэ. Бүх тэжээл, тэжээлийн орцыг муудах, бохирдохоос дээд зэргээр хамгаалж хадгалах, тээвэрлэх бөгөөд ингэснээр зөв тэжээлийг зохих бүлгийн мал, амьтанд хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

38. Тэжээл, тэжээлийн орцтой харьцах, хадгалах, тээвэрлэх бүх шатанд муудах, ялзрахыг дээд зэргээр багасгах арга хэмжээ авна. Чийгтэй, чийглэг тэжээлд мөөгөнцөр, бактерийн үржлийг хязгаарлахад онцгой анхаарна. Тэжээл, тэжээлийн орц үйлдвэрлэх, боловсруулах байранд конденсац үүсэхийг дээд зэргээр багасгана. Мөөгөнцөр, бактерийн үржлийг хязгаарлахын тулд хуурай тэжээл, тэжээлийн орцыг хуурайгаар нь байлгана.

39. Тэжээл, тэжээлийн орцын хаягдал, хэрэгцээгүй бодис, бусад аливаа аюулыг үл зөвшөөрөгдөх түвшинд агуулсан материалыг тэжээл болгон ашиглаж болохгүй, харин зохих журам, холбогдох хууль тогтоомжийн шаардлагын дагуу устгана.

5.3 Ажилтны сургалт

40. Тэжээл, тэжээлийн орцыг үйлдвэрлэх, хадгалах, харьцахад оролцож байгаа бүх ажилтан зохих ёсоор бэлтгэгдэж, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах үүрэг, хариуцлагыг ойлгож ухамсарласан байна.

5.4 Ариун цэвэр, хортон шавж, мэрэгчийн хяналт

41. Тэжээл, тэжээлийн орц, боловсруулах үйлдвэр, агуулах, тэдгээрийн ойр орчмыг цэвэр байлгаж, хортон шавж, мэрэгчийг хянах үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлнэ.

42. Үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, дамжуулах, харьцах, жинлэхэд хэрэглэх сав, тоног төхөөрөмжийг цэвэр байлгана. Цэвэрлэгээний ажлыг үр дүнтэй, угаалгын болон халдваргүйжүүлэх бодисын үлдэц хамгийн бага түвшинд байхаар зохион байгуулна.

43. Хуурай тэжээл, тэжээлийн орц хийхэд ашиглах машин, техникийг аливаа нойтон цэвэрлэгээ хийсний дараа хатаана.

44. Чийгтэй, чийглэг тэжээл, тэжээлийн орц хийхэд ашиглах машин, техникийг цэвэрлэхдээ мөөгөнцөр, бактери үржихээс сэргийлэхэд онцгой анхаарал тавина.

5.5 Тоног төхөөрөмжийн ажиллагаа, техникийн үйлчилгээ

45. Тэжээл, тэжээлийн орцыг үйлдвэрлэхэд ашиглах бүх төрлийн жин, хэмжих хэрэгсэл нь хэмжих жин, эзлэхүүнд тохирсон байхаас гадна тэдгээрийн тохирлыг тогтмол шалгана.

46. Тэжээл, тэжээлийн орцыг үйлдвэрлэхэд ашиглах аливаа холигч нь хольж байгаа зүйлийн жин болон эзлэхүүнд тохирсон, шаардлага хангасан нэгэн жигд холимог, нэгэн жигд шингэлэлтийг бэлтгэх чадавхтай байхаас гадна тэдгээрийн ажиллагааг тогтмол магадлан шалгана.

47. Тэжээл, тэжээлийн орцыг үйлдвэрлэхэд ашиглах бусад бүх тоног төхөөрөмж нь боловсруулж байгаа аливаа зүйлийн жин болон эзлэхүүнд тохирсон байхаас гадна тэдгээрт хяналт-шинжилгээ тогтмол хийдэг байна.

5.6 Үйлдвэрлэлийн хяналт

48. Хязгаарласан эсхүл хортой байж болох бусад материал (амьтны дайвар бүтээгдэхүүнээр хийсэн гурил, мал эмнэлгийн эм зэрэг) агуулсан тэжээл, тэжээлийн орцын цуврал хооронд солбицох бохирдол үүсгэхээс хамгаалж (жишээ нь угаах, ажлын дарааллыг мөрдөх, механик цэвэрлэгээ хийх гэх мэт) үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зохион байгуулна. Мөн үйлдвэрлэлийн явцад эмжүүлсэн болон ердийн тэжээл, бусад хоорондоо үл зохицох тэжээлийн хоорондын солбицох бохирдол үүсгэхээс хамгаална. Солбицох бохирдолтой холбоотой хүнсний аюулгүй байдлын эрсдэл өндөр, зөв угаах, цэвэрлэх аргыг зохих түвшинд хэрэглэсэн ч хангалтгүй гэж үзсэн тохиолдолд үйлдвэрлэлийн шугам, дамжуулах, хадгалах, хүргэх тусгай тоног төхөөрөмж ашиглах асуудлыг авч үзнэ.

49. Дулаанаар боловсруулах эсхүл зөвшөөрөгдсөн химийн бодис нэмэх зэргээр эмгэг төрүүлэгчийг хянах аргыг зохих тохиолдолд хэрэглэх, үйлдвэрлэлийн үйл явцын холбогдох үе шатад хяналт-шинжилгээ хийнэ.

5.7 Татан авалт

50. Хэрэглэгчийн эрүүл мэндэд эрсдэл учруулна гэж үзсэн аливаа тэжээл, тэжээлийн орцыг зах зээлээс нэн даруй татан авах, тэдгээр тэжээлийг идсэн мал, амьтныг олж тогтоох зорилгоор тэжээл, тэжээлийн орцын ялган таних тэмдэг, борлуулалт, түгээлтийн бүртгэл болон бусад мэдээллийг энэ дүрмийн 4.3-т заасны дагуу хадгална.

6 Хот айл, ферм дэх тэжээл, тэжээлийн орцын үйлдвэрлэл, хэрэглээ

51. Энэ хэсэгт тэжээл, тэжээлийн орцыг хот айл, фермийн нөхцөлд болон усны аж ахуйд тариалах, үйлдвэрлэх, зохион байгуулах, хэрэглэх удирдамжийг оруулав.

52. Энэ хэсгийг энэ дүрмийн 4 ба 5 дугаар хэсгийн зохих шаардлагатай хамтатган хэрэглэнэ.

53. Хүний хэрэгцээнд зориулсан хүнсний аюулгүй байдлыг хангахад туслахын тулд хүнсний зориулалтын мал, амьтанд зориулсан тэжээл, тэжээлийн орц болгон ашигладаг байгалийн бэлчээрийн өвс, үр тариа, таримал тэжээлийг хот айл, фермийн нөхцөлд үйлдвэрлэх бүх үе шатанд хөдөө аж ахуйн зохистой дадлыг¹² хэрэгжүүлнэ. Мөн ижил зарчмыг усны аж ахуйд мөрдөнө. Тэжээл, тэжээлийн орцыг хот айл, фермийн нөхцөлд үйлдвэрлэх ихэнх үе шатанд аюулыг илтгэх гурван төрлийн бохирдол байдаг. Тухайлбал:

- бактери, мөөгөнцөр, эмгэг төрүүлэгч бусад бичил биетэн зэрэг биологийн,
- эм, пестицид, бордоо, хөдөө аж ахуйн бусад бодисын үлдэц зэрэг химийн,
- хугархай зүү, машин, техникийн хэлтэрхий, гадны бусад материал зэрэг физикийн.

¹² Энэ тодорхойлолтын талаарх удирдамжийг ХХААБ-аас боловсруулж байна.

6.1 Хөдөө аж ахуйн тэжээл үйлдвэрлэл

54. Хүнсний зориулалтын мал, амьтанд зориулсан тэжээл, тэжээлийн орц болгон ашигладаг байгалийн болон сайжруулсан ургамал, таримал бэлчээрийн ургамал, түүнчлэн үр тарианы ургамал, тэжээлийн таримал ургамлын үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжинэ. Хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх нь хүнсний сүлжээнд биологи, хими, физикийн бохирдуулагч нэвтрэхийг дээд зэргээр багасгадаг. Ургац хураасны дараах үр тарианы үлдэгдэл, сүрэлтэй талбайд мал бэлчээрлүүлэх эсхүл тэдгээр нь өөр хэлбэрээр хүнсний сүлжээнд орох бол малын тэжээлтэй адилтган авч үзнэ. Малын хэвтэрт ашигладаг таримал ургамлын өвс, сүрэл болон модны үртсээр хийсэн хэвтрийн материалыг мал, амьтны тэжээлийн орцтой адилтган үзнэ. Бэлчээрийг сэлгэн ашиглах, өтөг бууцаар бордох зэрэг бэлчээрийн менежментийн зохистой дадлыг мал, амьтны сүрэг хоорондын солбицох бохирдлыг бууруулахад ашиглана.

6.1.1 Байршлын сонголт

55. Аж үйлдвэрийн гаралтай хортой бодис агаар, хөрсний усаар эсхүл зэргэлдээ талбайн урсцаар дамжин тарах замаар амьтны гаралтай хүнсний үйлдвэрлэлд нөлөөлөн хүнсний аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй тул мал, амьтны тэжээл бэлтгэх, тарих талбайг аж үйлдвэрлэл явуулдаг газарт ойр байрлуулж болохгүй. Зэргэлдээ талбайн урсац болон усжуулалтад ашиглах усан дахь бохирдуулагч бодисын агууламж хүнсний аюулгүй байдалд эрсдэл учруулах хэмжээнээс доогуур байна.

6.1.2 Бордоо

56. Таримал ургамал эсхүл бэлчээрийг өтөг бууцаар борддог бол тэдгээртэй харьцах, хадгалах тохирсон арга хэрэглэх, мал, амьтны гаралтай хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг хүрээлэн буй орчны бохирдлыг дээд зэргээр бууруулна. Өтөг бууц хэрэглэснээс хойш мал бэлчээх эсхүл таримал ургамал хураах (дарш, бухал өвс бэлтгэх) хүртэлх цаг хугацааг өтөг бууц задарч бохирдол үүсгэх нь дээд зэргээр бууртал оновчтой тогтооно.

57. Өтөг бууц, ургамлын бусад бордоог амьтны гаралтай хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох биологи, хими, физикийн бохирдол үүсэхээс дээд зэргээр бууруулах аргаар зөв зохистой хэрэглэнэ.

58. Химийн гаралтай бордоог амьтны гаралтай хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх байдлаар харьцаж, хадгалж, хэрэглэнэ.

6.1.3 Пестицид, хөдөө аж ахуйн бусад химийн бодис

59. Пестицид, хөдөө аж ахуйн бусад химийн бодисыг аюулгүй эх үүсвэрээс авна. Химийн бодисын талаар тогтоосон журам байгаа бол ашиглах химийн бодис түүний шаардлагыг хангасан байна.

60. Пестицидийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хадгалах ба “Пестицид ашиглах хөдөө аж ахуйн зохистой дадал”-ын (GAP)¹³ дагуу ашиглана. Малчид, фермерүүд хөдөө аж ахуйн бүх төрлийн химийн бодисыг ашиглахдаа үйлдвэрлэгчийн гаргасан зааврыг ягштал мөрдөнө.

61. Мал, амьтны гаралтай хүнсийг бохирдуулж, улмаар хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөөлж болзошгүй тул пестицид, хөдөө аж ахуйн бусад химийн

¹³ ХХЭЗХ-ны баримт бичгийн хүрээнд хэрэглэх тодорхойлолтыг үзнэ үү (ХХЭЗХ-ны “Процедурын гарын авлага”).

бодисыг ус, хөрс, тэжээл, тэжээлийн хольцыг бохирдуулахгүй байх аргаар хариуцлагатай устгана.

6.2 Хот айл, фермийн нөхцөлд тэжээл бэлтгэх

6.2.1 Тэжээлийн орц

62. Хот айл, фермийн нөхцөлд тэжээл үйлдвэрлэгч тэжээлийн орцыг гадны эх үүсвэрээс авахдаа энэ дүрмийн 4.1-т заасан холбогдох удирдамжийг дагаж мөрдөнө.

63. Хот айл, фермийн нөхцөлд үйлдвэрлэсэн тэжээлийн орц нь гадны тэжээлийн орцын эх үүсвэрт тавьдаг шаардлагыг хангасан байна. Жишээ нь: тариалалтанд хэрэглэхээр боловсруулалтанд оруулсан үрээр мал тэжээж болохгүй гэх мэт.

6.2.2 Холих

64. Хот айл, фермийн нөхцөлд тэжээл үйлдвэрлэгч энэ дүрмийн 5 дугаар хэсэгт заасан холбогдох удирдамжийг дагаж мөрдөнө. Ялангуяа дүрмийн 5.6-д онцгой анхаарал хандуулна.

65. Тэжээл, тэжээлийн орцын аюулгүй байдал, хадгалах хугацаанд нөлөөлж болзошгүй тул тэжээлийг холихдоо ялангуяа тэжээл, тэжээлийн орц хоорондын солбицох бохирдлыг дээд зэргээр багасгах байдлаар холино.

6.2.3 Хяналт-шинжилгээний бүртгэл

66. Тэжээлээс хамааралтай болзошгүй бохирдол эсхүл өвчнийг мөшгөн судлахад ашиглахын тулд хот айл, фермийн нөхцөлд тэжээл үйлдвэрлэгч тэжээл үйлдвэрлэлд дагаж мөрддөг арга ажиллагааны бүртгэл, тэмдэглэлийг зохих ёсоор хөтөлнө.

67. Энэ дүрмийн 4.3-т даасан холбогдох бүртгэлээс гадна гаднаас авсан тэжээлийн орц, хүлээн авсан огноо, үйлдвэрлэсэн тэжээлийн багцын бүртгэл хөтөлнө.

6.3 Мал, амьтан тэжээх зохистой дадал

68. Мал, амьтан тэжээх зохистой дадалд хот айл, фермийн түвшинд тэжээл, тэжээлийн орцыг зөв зохистой ашиглахын зэрэгцээ мал, амьтны гаралтай хүнснээс хэрэглэгчдэд учирч болох биологи, хими, физикийн бохирдлын эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахад чиглэсэн дадлууд орно.

6.3.1 Ус

69. Мал, амьтны уух ус эсхүл усны аж ахуйн ус нь тухайн өсгөн үржүүлж байгаа мал, амьтанд тохирсон чанартай байна. Мал, амьтанд усны бохирдлоос шалтгаалсан асуудал гарвал аюулыг үнэлэх, хамгийн бага түвшинд хүргэх арга хэмжээ авна.

6.3.2 Бэлчээр

70. Биологи, хими, физикийн аюулаар мал, амьтны гаралтай хүнс бохирдох явдлыг дээд зэргээр бууруулах байдлаар байгалийн болон таримал бэлчээрийг зохицуулна.

71. Зохих тохиолдолд мал сүргийг бэлчээрийн, таримал тэжээлийн болон ургацын үлдэгдэлтэй талбайд бэлчээхийн өмнө, түүнчлэн бэлчээр сэлгэлтийн хооронд хүлээх тохиромжтой хугацааг баримталж өтөг бууцнаас үүсэх биологийн

солбицох бохирдлыг дээд зэргээр бууруулна.

72. Аж ахуй эрхлэгч хөдөө аж ахуйн химийн бодис хэрэглэж байгаа бол шаардлагатай хүлээх хугацааг баримтална.

6.3.3 Тэжээх

73. Тэжээх шаардлагатай мал, амьтныг тохирсон тэжээлээр, хэрэглэх зааврыг баримтлан тэжээх нь чухал. Тэжээж байх үед тэжээл бохирдох боломжийг дээд зэргээр бууруулна. Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг удирдахын тулд мал, амьтныг ямар тэжээлээр хэзээ тэжээсэн талаарх мэдээллийг ашиглахад бэлэн байлгана.

74. Эмжүүлсэн тэжээлээр тэжээж байгаа мал, амьтныг эм гадагшилж дуусах тогтоосон хугацаанд нь ялган тэмдэглэж зохих ёсоор хяналтад байлгах ба эдгээр үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийг хөтөлнө. Эмжүүлсэн тэжээлийг хэрэгцээтэй газарт тээвэрлэн хүргэж, эмчлэх шаардлагатай мал, амьтныг тэжээх журмыг мөрдөнө. Төрөл бүрийн эмжүүлсэн тэжээл, ердийн тэжээл, эсхүл тэжээлийн хольцод ээлжлэн хэрэглэх бол эмжүүлсэн тэжээл хүргэх, тараахад хэрэглэсэн тэжээл тээвэрлэх машин, тэжээлийн тоног төхөөрөмжийг ашигласны дараа цэвэрлэнэ.

6.4 Байран тэжээх, бордох цэг/ бордооны эрчимжсэн нэгж

75. Мал, амьтны байран тэжээх, бордох газрыг хүнсний аюулгүй байдалд эрсдэл учруулахгүйгээр мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тохирсон газарт байрлуулна. Мал, амьтныг бохирдсон газар, хордлогын эх үүсвэртэй байгууламжид нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

6.4.1 Эрүүл ахуй

76. Мал, амьтан байран тэжээх, бордох газрыг байгуулахдаа сайтар цэвэрлэх боломжтой байхаар төлөвлөнө. Хүнсний аюулгүй байдалд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд мал, амьтан байран тэжээх, бордох газар, түүний тэжээлийн тоног төхөөрөмжийг тогтмол хугацаанд бүрэн цэвэрлэж байна. Тэжээл үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх ажилд тохирсон химийн бодисыг зааврын дагуу хэрэглэнэ. Эдгээр бодисыг зөв шошголж тэжээл үйлдвэрлэх, агуулах, мал, амьтан тэжээх хэсгээс зайдуу хадгална.

77. Хүнсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй аюулыг дээд зэргээр бууруулахын тулд мал, амьтан байран тэжээх, бордох газарт хортон мэрэгч нэвтрэхээс сэргийлэх хяналтын ажлыг хэрэгжүүлдэг байна.

78. Хүнсний аюулгүй байдалд тэжээлээс учирч болзошгүй аюулыг дээд зэргээр бууруулахын тулд мал, амьтан байран тэжээх, бордох газрын эрхлэгч, ажиллаж буй хүмүүс эрүүл ахуйн зохих шаардлагыг дагаж мөрдөнө.

6.5 Усны аж ахуй¹⁴

79. Усны ургамал, амьтны аж ахуй нь загас, нялцгай биетэн, хавч хэлбэртэн, наймаалж зэрэг маш олон төрөл, зүйлийг хамарна. Усны ургамал, амьтны аж ахуйд задгай тэнгис далайд байгуулсан үлэмж том торон байгууламжаас эхлээд цэвэр устай жижиг цөөрмийг хүртэл ашиглан амьтан, ургамал үржүүлэх төрөл бүрийн нарийн, нийлмэл арга хэрэглэнэ. Ийм олон янз байдал нь амьтныг бие гүйцэх

¹⁴ Усны аж ахуй эрхлэгч “Загас, загасан бүтээгдээгдэхүүний зохистой дадлын дүрэм”-ийн холбогдох хэсгээс нэмэлт мэдээлэл авна уу(CAC/RCP 52-2003).

хүртэл олон шат дамжуулан өсгөн үржүүлэхэд янз бүрийн тэжээл, үржүүлгийн төрөл бүрийн арга шаарддаг. Тэжээллэгийн хувьд зөвхөн усанд агуулагдах байгалийн тэжээллэг бодисыг хэрэглэхээс гадна нарийн тоног төхөөрөмж, шинжлэх ухааны үндэстэй тогтоосон олон найрлагатай тэжээлийг хэрэглэнэ.

80. Хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүнсний аюулыг бууруулахын тулд аливаа өсгөн үржүүлэх арга, үржүүлгийн газар, технологи, материал, тэжээлд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, бохирдлыг дээд зэргээр бууруулна.

7 Сорьц түүвэрлэлт, шинжилгээний арга

7.1. Сорьц түүвэрлэлт

81. Түүвэрлэлтийн арга нь шинжлэх ухаанаар хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, журамд нийцсэн байна.

7.2 Шинжилгээ

82. Шинжлэх ухааны хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, журамд нийцүүлэн боловсруулж баталгаажуулсан лабораторийн аргыг ашиглана¹⁵. Аргыг сонгохдоо практикт хэрэглэх боломжийг харгалзахын зэрэгцээ найдвартай, тогтмол хэрэглэхэд тохиромжтой байдлыг эрхэмлэнэ. Тэжээл, тэжээлийн орцын шинжилгээг тогтмол хийдэг лаборатори өөрийн хэрэглэдэг арга тус бүрээр шинжилгээний ажлын ур чадварыг баталгаажуулж, зохих баримт бичгийг хөтөлж хадгална¹⁶.

¹⁵ “Шинжилгээний аргыг сонгох ерөнхий шалгуур” (ХХЭЗХ-ны “Процедурын гарын авлага”).

¹⁶ Жишээ нь: ISO 17025 зэрэг чанарын магадлан итгэмжлэлийн тогтолцоогоор